# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

## 2017 оны 1 дүгээр сар

**Ерөнхий тойм:** Энэ оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 33.6%-иар буюу 177.4 сая ам.доллараар өсч 705.7 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 30.2%-иар буюу 99.4 сая ам.доллараар, импорт 39.2%-иар буюу 78.0 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 151.4 сая ам.доллараар давж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 21.4 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

**Хүснэгт 1.** Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | Жилээр | | | Өөрчлөлт | | | | 1 дүгээр сар | | | Өөрчлөлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2014 | 2015 | 2016 | 2015/2014 | | 2016/2015 | | 2015 | 2016 | 2017 | 2016/2015 | | 2017/2016 | |
| | | | | Дүн | Хувь | Дүн | Хувь | | | | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| **Эргэлт** | **11,011** | **8,467** | **8,275** | **(2,544)** | **-23.1%** | **(192)** | **-2.3%** | **720** | **528** | **705.7** | **(192)** | **-26.6%** | **177.4** | **33.6%** |
| Экспорт | 5,774 | 4,669 | 4,917 | (1,105) | -19.1% | 248 | 5.3% | 473 | 329 | 428.5 | (144) | -30.4% | 99.4 | 30.2% |
| Импорт | 5,237 | 3,798 | 3,358 | (1,439) | -27.5% | (440) | -11.6% | 247 | 199 | 277.2 | (48) | -19.5% | 78.0 | 39.2% |
| **Тэнцэл** | **538** | **872** | **1,559** | **334** | | **688** | **78.9%** | **225** | **130** | **151.4** | **(95)** | **-42.3%** | **21.4** | **16.4%** |

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2017 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр 165.3 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 27.9 сая ам.доллараар өссөн байна.

**Зураг 1.** Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




**Зураг 2.** Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар




**Хөрш орнуудтай хийсэн худалдаа**г авч үзвэл, нийт бараа эргэлтийн 68.0% буюу 479.7 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 11.9% буюу 84.3 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 36.1%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 58.8%-иар тус тус өссөн байна.

**Зураг 3.** Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/




**Хүснэгт 2.** Худалдааны нөхцөлийн индекс /2012 оны 12 сар суурьтай/

| Үнийн индексийн төрөл* | 2016.01 сар | 2016.12 сар | 2017.01 сар | Жил Δ | Сар Δ |
|---|---|---|---|---|---|
| **Экспорт** | **0.69** | **0.85** | **0.93** | **35%** | **10%** |
| Зэсийн баяжмал | 0.36 | 0.34 | 0.36 | 1% | 5% |
| Чулуун нүүрс | 0.37 | 0.56 | 0.62 | 66% | 11% |
| Ямааны угаасан ноолуур | 0.32 | 0.34 | 0.40 | 23% | 18% |
| **Импорт** | **0.61** | **0.55** | **0.58** | **-4%** | **6%** |
| Хэрэглээний бараа | 0.77 | 0.72 | 0.73 | -6% | 1% |
| Хөрөнгө оруулалтын бараа | 0.59 | 0.48 | 0.55 | -7% | 14% |
| Нефтийн бүтээгдэхүүн | 0.46 | 0.49 | 0.50 | 8% | 2% |
| **Худалдааны нөхцөл** | **1.14** | **1.55** | **1.60** | **41%** | **3%** |

* Индексийн өөрчлөлтөд голлох хувь нэмэр оруулсан бараагаар задлав.

**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 40.6%-иар, өмнөх сараас 3.3%-иар өсч 1.602-д хүрлээ. Тайлант сард нефть, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортын үнэ өссөн хэдий ч нүүрс, зэсийн экспортын үнэ өссөнөөс худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирсан байна.

** Энэхүү тоймыг ГТЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.*

Экспорт 2017 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 30.2%-иар буюу 99.4 сая ам.доллараар өссөн. Уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлт нь нийт экспортыг 32.8 нэгж хувиар өсөхөд нөлөөлсөн бол бусад төрлийн экспорт нь нийт экспортыг 2.6 нэгж хувиар буурахад нөлөөлжээ. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 5.1 нэгж хувиар өссөн бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний жин 2.1 нэгж хувиар буурсан байна.

**Хүснэгт 3.** Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | 2015 | | | 2016 | | | 2017 | | | Δ (2016/2015) | | | Δ (2017/2016) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Дүн | Өсөлт | %² | Дүн | Өсөлт | %² |
| **1. Уул уурхай** | | **422** | **89%** | | **285** | **87%** | | **393** | **92%** | **(137)** | **-32%** | **-29%** | **108** | **38%** | **32.8%** |
| 1.1. Зэсийн хүдэр, баяжмал | 133 | 268 | 57% | 140 | 178 | 54% | 134 | 137 | 32% | (90) | -34% | -19% | (41) | -23% | -12% |
| 1.2. Чулуун нүүрс | 1,106 | 38 | 8% | 1,156 | 34 | 10% | 2,592 | 168 | 39% | (4) | -11% | -1% | 134 | 391% | 41% |
| 1.3. Боловсруулаагүй нефть | 691 | 33 | 7% | 779 | 25 | 7% | 593 | 31 | 7% | (8) | -24% | -2% | 6 | 25% | 2% |
| 1.4. Төмрийн хүдэр, баяжмал | 343 | 21 | 4% | 475 | 13 | 4% | 260 | 15 | 4% | (8) | -37% | -2% | 2 | 15% | 1% |
| 1.5. Мөнгөжөөгүй алт /кг/ | 1,018 | 40 | 9% | 715 | 25 | 8% | 467 | 18 | 4% | (15) | -37% | -3% | (7) | -28% | -2% |
| 1.6. Цайрын хүдэр, баяжмал | 9 | 11 | 2% | 3 | 3 | 1% | 9 | 12 | 3% | (9) | -77% | -2% | 10 | 382% | 3% |
| 1.7. Жонш, лейцит, нефелинт | 18 | 4 | 1% | 16 | 4 | 1% | 19 | 4 | 1% | (0) | -10% | 0% | 1 | 18% | 0% |
| 1.8. Молибдений хүдэр, баяжмал | 0 | 3 | 1% | 1 | 2 | 1% | 0 | 2 | 0% | (2) | -44% | 0% | (0) | -4% | 0% |
| 1.9. Гянтболдын хүдэр, баяжмал | 0 | 1 | 0% | 0 | 1 | 0% | 0 | - | 0% | (0) | -32% | 0% | (1) | -100% | 0% |
| 1.10. Мөнгө /тонн/ | 10 | 3 | 1% | 4 | 1 | 0% | 0 | - | 0% | (2) | | 0% | (1) | -100% | 0% |
| 1.11. Бусад | 0 | 0 | 0% | 4 | 0 | 0% | 46 | 5 | 1% | 0 | 25476% | 0% | 5 | | 1% |
| **2. Мал аж, ахуй** | | **13** | **3%** | | **20** | **6%** | | **16** | **4%** | **7** | **56%** | **2%** | **(4)** | **-19%** | **-1.2%** |
| 2.1. Амьд мал, малын мах | 0 | 1 | 0% | 0 | 1 | 0% | 1 | 2 | 1% | 0 | 40% | 0% | 1 | 98% | 0% |
| 2.2. Арьс, шир | 46 | 5 | 1% | 37 | 9 | 3% | 45 | 4 | 1% | 4 | 74% | 1% | (5) | -52% | -1% |
| 2.3. Малын өлөн гэдэс | 0 | 0 | 0% | 0 | 0 | 0% | 0 | - | 0% | 0 | 196% | 0% | (0) | -100% | 0% |
| 2.4. Ноолуур | 1 | 6 | 1% | 1 | 8 | 2% | 1 | 9 | 2% | 2 | 34% | 0% | 1 | 15% | 0% |
| 2.5. Ноос, бусад үс, хялгас | 1 | 1 | 0% | 1 | 2 | 1% | 0 | 1 | 0% | 1 | 81% | 0% | (2) | -67% | 0% |
| 2.6. Бусад | 0 | 0 | 0% | 0 | 0 | 0% | 0 | 0 | 0% | 0 | 426% | 0% | 0 | 1094% | 0% |
| **3. Газар тариалан** | | **11** | **2%** | | **3** | **1%** | | **1** | **0%** | **(8)** | **-74%** | **-2%** | **(2)** | **-76%** | **-0.6%** |
| **4. Аж үйлдвэрлэл** | | **26** | **6%** | | **21** | **6%** | | **18** | **4%** | **(6)** | **-22%** | **-1%** | **(3)** | **-13%** | **-0.8%** |
| 4.1. Хүнс | 0 | 9 | 2% | 1 | 9 | 3% | 1 | 5 | 1% | 0 | 5% | 0% | (4) | -44% | -1% |
| 4.2. Ноолууран эдлэл | 0 | 1 | 0% | 0 | 1 | 0% | 0 | 1 | 0% | (0) | -33% | 0% | 1 | 55% | 0% |
| 4.3. Бусад хувцас, гутал, эдлэл | 0 | 0 | 0% | 0 | 1 | 0% | 0 | 1 | 0% | 1 | 206% | 0% | (0) | -15% | 0% |
| 4.4. Уул уурхай | 1 | 6 | 1% | 2 | 7 | 2% | 2 | 8 | 2% | 1 | 12% | 0% | 1 | 22% | 0% |
| 4.5. Цахилгаан, электрон бараа | 0 | 0 | 0% | 0 | 0 | 0% | 0 | 0 | 0% | (0) | -40% | 0% | (0) | -62% | 0% |
| 4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги | 0 | 9 | 2% | 0 | 3 | 1% | 0 | 2 | 1% | (7) | -69% | -1% | (1) | -24% | 0% |
| 4.7. Бусад | 24 | 1 | 0% | 16 | 0 | 0% | 23 | 0 | 0% | (1) | -86% | 0% | 0 | 316% | 0% |
| **5. Бусад** | | **0** | **0%** | | **0** | **0%** | | **0** | **0%** | **(0)** | **-60%** | **0%** | **(0)** | **-7%** | **0.0%** |
| **Нийт дүн** | | **473** | | | **329** | | | **429** | | **(144)** | **-30%** | | **99.4** | **30.2%** | |

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 4.** Экспортын өөрчлөлт, 2017 он

| Төрөл | Тоо хэмжээний өөрчлөлт | % | Үнийн өөрчлөлт | % | Нийт өөрчлөлт | % |
|---|---|---|---|---|---|---|
| **1. Уул уурхай** | **67.6** | **63%** | **40.4** | **37%** | **108.0** | **38%** |
| 1.1. Зэсийн хүдэр, баяжмал | (6.2) | 15% | (34.5) | 85% | (40.7) | -23% |
| 1.2. Чулуун нүүрс | 93.3 | 70% | 40.9 | 30% | 134.1 | 391% |
| 1.3. Боловсруулаагүй нефть | (9.6) | -159% | 15.7 | 259% | 6.1 | 25% |
| 1.4. Төмрийн хүдэр, баяжмал | (12.6) | -650% | 14.5 | 750% | 1.9 | 15% |
| 1.5. Мөнгөжөөгүй алт /кг/ | (9.7) | 136% | 2.6 | -36% | (7.1) | -28% |
| 1.6. Цайрын хүдэр, баяжмал | 7.9 | 82% | 1.7 | 18% | 9.6 | 382% |
| 1.7. Жонш, лейцит, нефелинт | 0.6 | 90% | 0.1 | 10% | 0.7 | 18% |
| 1.8. Молибдений хүдэр, баяжмал | (0.8) | | 0.8 | | (0.1) | -4% |
| 1.11. Бусад | 4.8 | 98% | 0.1 | 2% | 4.8 | 0% |
| **2. Мал аж, ахуй** | **1.6** | **-40%** | **(5.5)** | **140%** | **(3.9)** | **-19%** |
| 2.2. Арьс, шир | 0.8 | -17% | (5.3) | 117% | (4.6) | -52% |
| 2.4. Ноолуур | 0.8 | 71% | 0.3 | 29% | 1.1 | 15% |
| **3. Газар тариалан** | **(12.6)** | **606%** | **10.5** | **-506%** | **(2.1)** | **-76%** |
| **4. Аж үйлдвэрлэл** | **0.9** | **-33%** | **(3.5)** | **133%** | **(2.6)** | **-13%** |
| **5. Бусад** | **(0.0)** | **100%** | **-** | **0%** | **(0.0)** | **-7%** |
| **Нийт дүн** | **57.4** | **58%** | **42.0** | **42%** | **99.4** | **30%** |

** Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.*

2017 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 57.4 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 42.0 сая ам.доллараар өссөн байна. Уул уурхайн түүхий эдийн экспорт нүүрсний экспортын биет хэмжээ, үнэ өссөнөөс голлон шалтгаалж 108.0 сая ам.доллараар өссөн байна. Мал аж, ахуйн түүхий эдийн экспорт үнэ буурснаас голлон шалтгаалж 3.9 сая ам.доллараар буурсан байна. Харин аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт биет хэмжээ өссөн хэдий ч үнэ буурснаас 2.6 сая ам.доллараар буурчээ.

**Зураг 4.** Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ




Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2017 оны 1 дүгээр сард 1,194 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.8%-иар, өнгөрсөн сараас 3.8%-иар тус тус өсчээ. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ тайлант сард харгалзан 5,755, 81 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 29%-иар, төмрийн хүдэр 91%-иар, өнгөрсөн сартай харьцуулахад харгалзан 2%, 0.5%-иар тус тус өссөн байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 1 дүгээр сард **65** ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс **119%**-иар, өмнөх сараас **19%**-иар тус тус нэмэгдэв.

Импорт 2017 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 39.2%-иар буюу 78.0 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 18 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 14 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 6 нэгж хувийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 6 нэгж хувиар буурсан бол нефтийн бүтээгдэхүүний жин 6 нэгж хувиар өсчээ.

**Хүснэгт 5.** Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | 2015 | | | 2016 | | | 2017 | | | Δ (2016/2015) | | | Δ (2017/2016) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Дүн | Өсөлт | %² | Дүн | Өсөлт | %² |
| **Хэрэглээний бүтээгдэхүүн** | | **84** | **34%** | | **74** | **37%** | | **86** | **31%** | **(10)** | **-12%** | **-4%** | **12** | **16%** | **6%** |
| Түргэн эдэлгээтэй | 47 | 47 | 19% | 59 | 43 | 21% | 71 | 49 | 18% | (4) | -10% | -2% | 7 | 15% | 3% |
| *Хүнс* | *26* | 33 | *13%* | *27* | 30 | *15%* | *23* | 31 | *11%* | *(3)* | *-10%* | *-1%* | *1* | *3%* | *1%* |
| *Эм, тариа* | *0* | 5 | *2%* | *0* | 4 | *2%* | *0* | 8 | *3%* | *(1)* | *-20%* | *0%* | *4* | *84%* | *2%* |
| *Бусад түргэн эдэлгээтэй бараа* | *21* | 8 | *3%* | *32* | 8 | *4%* | *48* | 10 | *4%* | *(0)* | *0%* | *0%* | *2* | *22%* | *1%* |
| Удаан эдэлгээтэй | 12 | 37 | 15% | *11* | 32 | 16% | *34* | 37 | 13% | (5) | -14% | -2% | 5 | 17% | *3%* |
| *Гутал, хувцас, цүнх* | *5* | 4 | *1%* | *6* | 3 | *1%* | *6* | 4 | *2%* | *(1)* | *-17%* | *0%* | *1* | *43%* | *1%* |
| *Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга* | *2* | 9 | *4%* | *0* | 6 | *3%* | *19* | 10 | *4%* | *(3)* | *-30%* | *-1%* | *3* | *52%* | *2%* |
| *Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл* | *0* | 19 | *8%* | *0* | 18 | *9%* | *0* | 19 | *7%* | *(1)* | *-7%* | *-1%* | *1* | *6%* | *1%* |
| *Бусад удаан эдэлгээтэй бараа* | *5* | 5 | *2%* | *5* | 4 | *2%* | *8* | 4 | *1%* | *(1)* | *-11%* | *0%* | *(0)* | *-4%* | *0%* |
| **Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн** | | **67** | **27%** | | **59** | **30%** | | **95** | **34%** | **(8)** | **-12%** | **-3%** | **36** | **61%** | **18%** |
| Машин, механик тоног төхөөрөмж, эд анги | 1 | 40 | 16% | 1 | 38 | 19% | 3 | 72 | 26% | (3) | -7% | -1% | 34 | 90% | 17% |
| *Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги* | 0 | 6 | *2%* | 0 | 7 | *3%* | 0 | 9 | *3%* | *1* | *12%* | *0%* | *2* | *26%* | *1%* |
| *Машин механик, тоног төхөөрөмж, эд анги* | 1 | 34 | *14%* | 1 | 31 | *16%* | 3 | 63 | *23%* | *(3)* | *-10%* | *-1%* | *32* | *104%* | *16%* |
| Барилгын материал | 32 | 17 | 7% | 22 | 14 | 7% | 17 | 14 | 5% | (2) | -15% | -1% | (0) | -1% | 0% |
| Хөрөнгө оруулалтын бусад бараа | 3 | 10 | 4% | 2 | 7 | 4% | 3 | 9 | 3% | (3) | -29% | -1% | 2 | 29% | 1% |
| **Аж үйлдвэрлэлийн орц** | | **34** | **14%** | | **36** | **18%** | | **37** | **13%** | **2** | **5%** | **1%** | **1** | **3%** | **0%** |
| Хүнсний орц | 4 | 2 | 1% | 23 | 5 | 3% | 4 | 1 | 0% | 4 | 222% | 1% | (4) | -75% | -2% |
| Химийн бүтээгдэхүүн | 7 | 4 | 2% | 8 | 5 | 3% | 10 | 6 | 2% | 1 | 21% | 0% | 1 | 19% | 0% |
| Даавуу, утас, арьс, савхин эдлэл | 2 | 1 | 0% | 2 | 1 | 0% | 2 | 2 | 1% | (0) | -15% | 0% | 1 | 79% | 0% |
| Цахилгаан эрчим хүч | 0 | 9 | 4% | 0 | 11 | 5% | 0 | 10 | 4% | 2 | 22% | 1% | (0) | -4% | 0% |
| Металлын хүдэр, баяжмал болон хаягдал | 0 | 0 | 0% | 0 | 0 | 0% | 0 | 0 | 0% | (0) | -22% | 0% | (0) | -21% | 0% |
| Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат | 73 | 18 | 7% | 43 | 14 | 7% | 61 | 17 | 6% | (5) | -26% | -2% | 4 | 27% | 2% |
| **Нефтийн бүтээгдэхүүн** | **87** | **61** | **25%** | **58** | **30** | **15%** | **103** | **58** | **21%** | **(31)** | **-51%** | **-13%** | **28** | **96%** | **14%** |
| Дизель түлш | 41 | 28 | 12% | 29 | 14 | 7% | 68 | 36 | 13% | (15) | -51% | -6% | 22 | 158% | 11% |
| АИ-92, АИ-95 | 38 | 26 | 11% | 23 | 11 | 6% | 26 | 15 | 6% | (15) | -56% | -6% | 4 | 35% | 2% |
| А-80 болон бусад | 8 | 6 | 3% | 6 | 4 | 2% | 9 | 7 | 3% | (2) | -31% | -1% | 3 | 60% | 1% |
| **Бусад** | **2** | **1** | **0%** | **0** | **0** | **0%** | **5** | **1** | **0%** | **(0)** | | **0%** | **1** | | **0%** |
| **Нийт дүн** | | **247** | | | **199** | | | **277** | | **(48)** | **-19.5%** | | **78.0** | **39.2%** | |

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 6.** Импортын өөрчлөлт, 2017 он

| Төрөл* | Тоо хэмжээний өөрчлөлт | % | Үнийн өөрчлөлт | % | Нийт өөрчлөлт | % |
|---|---|---|---|---|---|---|
| **Хэрэглээний бүтээгдэхүүн** | **7.2** | 60% | **4.8** | 40% | **12.0** | **16%** |
| Түргэн эдэлгээтэй | 5.8 | 89% | 0.7 | 11% | 6.5 | 15% |
| Удаан эдэлгээтэй | 1.4 | 25% | 4.1 | 75% | 5.5 | 17% |
| **Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн** | **37.2** | **103%** | **(1.1)** | **-3%** | **36.1** | **61%** |
| Машин, механик тоног төхөөрөмж, эд ангı | 36.4 | 107% | (2.3) | -7% | 34.1 | 90% |
| Барилгын материал | (1.0) | 719% | 0.9 | -619% | (0.1) | -1% |
| Хөрөнгө оруулалтын бусад бараа | 1.8 | 87% | 0.3 | 13% | 2.1 | 29% |
| **Аж үйлдвэрлэлийн орц** | **(0.9)** | | **1.8** | | **1.0** | **3%** |
| **Нефтийн бүтээгдэхүүн** | **24.7** | **87%** | **3.7** | **13%** | **28.5** | **96%** |
| Дизель түлш | 20.1 | 92% | 1.7 | 8% | 21.8 | 158% |
| АИ-92, АИ-95 | 2.2 | 56% | 1.8 | 44% | 4.0 | 35% |
| А-80 болон бусад | 2.4 | 91% | 0.2 | 9% | 2.7 | 60% |
| **Бусад** | **0.7** | **123%** | **(0.1)** | **-23%** | **0.5** | **0%** |
| **Нийт дүн** | **68.9** | **88%** | **9.1** | **12%** | **78** | **39%** |

** Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.*

2017 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр импорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 69 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 9 сая ам.доллараар тус тус өсчээ. Хэрэглээний бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ болон үнэ нэмэгдсэнээс шалтгаалан уг бүлгийн импорт 12.0 сая ам.доллараар өсчээ. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 61%-иар өссөн нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импорт 96%-иар өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2017 оны 1 дүгээр сарын байдлаар тонн тутамд 564.3 ам.долларт хүрч 4 сар дараалан өсөөд байна.

**Зураг 5.** Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/

